

**“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 10

№ 25/03

Дархан –Уул аймаг

**“ Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

“ Дархан зочид буудал” ХК-ийн 2025 оны 03 сарын 10-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс санал авсан хуудасны дүн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний 14:00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центропонт төв “Бурхан халдун групп” –ын байрнд хуралдуулсугай.
2. “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 - Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах.
 - 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
 - ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
3. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТөвөөс 2025 оны 04 сарын 01 –ний өдөр / **бүртгэлийн өдөр** /-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 03 сарын 13-ны өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр , 2025 оны 03 сарын 27-ны өдөр дахин мэдээлхийг хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа-д даалгасугай.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг ТУЗ-ийн нарийн бичиг С.Дагиймаа-д гаргаж өгхийг санхүүд даалгасугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь **Хавсралт1**-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “ саналын хуудас”ны агуулгыг **Хавсралт 2**-д зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг **2025 оны 04 сарын 29-ний өдрийн 14 цагаар** тасалбар болгосугай.
9. Компанийн ээлжит хурал удирдах даргаар ТУЗ-ийн дарга П.Алимаа-г зохион байгуулах комиссын даргаар С.Дагиймаа-г, Тооллогын комиссын даргаар Ю.Түвшинтөгс, гишүүнээр С.Оюундэлгэрийг тус тус томилсугай.
10. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Дархан зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг **Хавсралт3** –д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо,Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ДАРХАН ЗОЧИД
БУУДАЛ
ХК

ТТГ5656 д. 2024802

/ П.АЛИМАА /